



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 5-р сарын 29-өөс
6-р сарын 4-ний байдлаар

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 5-р сарын 29-өөс 6-р сарын 4-ний байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 12 дахь дугаарыг хүргэж байна.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- Дэлхийн эдийн засгийн сэргэлтийн үйл явц тогтвортой бус байх төлөвтэй байгааг “Goldman Sachs”-ийн Ерөнхийлөгч Жон Уолдрон анхаарууллаа. КОВИД-19-ийн нөлөөгөөр дэлхийн эдийн засаг 2020 онд 4 хувиар агшихаар төсөөлөгдөж байгаа бөгөөд 2021 онд агшилт илүү гүнзгий байж болзошгүй гэжээ. Эдийн засгийн сэргэлт “W” хэлбэртэй өрнөвөл бэрхшээл дагуулах бөгөөд ялангуяа, төсвийн дэмжлэг сул үед хэрэглэгчдэд илүү хүндээр тусна гэдгийг анхаарууллаа.
- АНУ-ын бүх мужууд хөл хориогоо сулруулж, бизнесүүд алгуур эргэн нээгдэж байна. Блүүмберг агентлагаас тооцдог Хэрэглэгчийн индекс¹ алгуур сайжирч байна. Тус индекс 3-р сарын дунд үед 63 байсан бол 5-р сарын дунд үеийг хүртэл 34.7 хүртэл унаж, 5-р сарын 23-ны долоо хоногт 35.5 болж бага зэрэг эргэж нэмэгдлээ. Кафе, ресторанууд 5-р сараас нээгдэж, захиалгын тоо өмнөх долоо хоногт жилийн -87 хувийн уналттай байсан бол энэ долоо хоногт жилийн -82 хувь болж буурчээ.
- НҮБ-аас 6-р сарын 1-нд нийтэлсэн “Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, ирээдүйн төлөв” тайланд эрчимтэй хөгжиж буй орнуудын эдийн засаг 2020 онд 3.2 хувиар агших төсөөллийг гаргажээ. Үүнд Бразил, Мексик, Өмнөд Африк зэрэг орнуудын эдийн засаг 4.5-аас өндөр хувиар агших бол Индонезийн эдийн засаг эерэг өсөлттэй байх төлөвтэй байна. Эдийн засгийн огцом уналтын улмаас олон сая хүмүүс ажлын байраа алдаж, ядуурал, тэгш бус байдал цар тахлын өмнөхтэй харьцуулахад даамжирч, нэмэгдэхээр байна гэжээ.
- АНУ-ын хөдөлмөрийн зах зээлийн төлөв сайнгүй байна. АНУ-ын ажилгүйдлийн тэтгэмж шинээр хүсэгчдийн тоо КОВИД-19 цар тахал дэлгэрснээс хойш анх удаа буурч, 5-р сарын 16-23-нд 2.4 сая, 5-р сарын 23-30-нд 2.1 сая болсон талаар тус улсын Хөдөлмөрийн яам мэдээллээ. Гэхдээ 2.1 сая хүсэлт нь цар тахлын өмнөх үеийн түвшнээс 10 дахин өндөр үзүүлэлт юм. АНУ-д КОВИД-19-ийн тархалт үргэлжилсэн хэвээр байгаа тул ажлын байрны цомхотголын хоёр дахь давлагаа бий болох буюу 6 сая гаруй боловсролтой ажиллах хүчин ажлаа алдаж болзошгүйг Блүүмбергийн

¹ The Bloomberg Consumer Comfort Index

шинжээчид анхааруулж байна. АНУ-ын ажилгүйдлийн түвшин 2020 онд 12 хувь, 2021 онд 8 орчим хувь байхаар “Goldman Sachs”-ийн эдийн засагчид тооцож байна.

- **Франц улс** 2 сар гаруй хугацаанд үргэлжлүүлсэн хөл хориог 5-р сарын дундаас сулруулж, кафе, зоогийн газрууд эхнээсээ нээгдэж, **эдийн засгийн идэвхжил алгуур сэргэж эхэллээ**. Гэхдээ Францын сангийн сайд Бруно Ле Мэрийн мэдэгдсэнээр тус улсын эдийн засаг 2020 онд 11 хувиар агших хүлээлттэй байна.
- **Германы Засгийн газар** цар тахалтай тэмцэж, эдийн засгийг дэмжих хоёр дахь удаагийн арга хэмжээ буюу 111 тэрбум ам.доллартай тэнцэх багц хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.
- **Австралийн Засгийн газар 476 сая ам.доллартай тэнцэх төсвийн дэмжлэгийг орон сууцны барилгын салбарыг дэмжих багц хөтөлбөрт зарцуулахаа зарлалаа**. 2020 оны эцэст дуусах уг хөтөлбөрийн хүрээнд шинээр байшин барьж буй болон гэрээ шинэчлэн, өөрчилж буй хүн бүрт 25 мянган австрали доллар бэлнээр олгох юм. Ингэснээр улсын эдийн засгийн нийт үйлдвэрлэлийн 5 хувийг бүрдүүлдэг барилгын салбарын 140,000 гаруй шууд ажлын байр, 1 сая гаруй дам ажлын байрыг дэмжих зорилготой.
- Ройтерс агентлагаас эдийн засагчдын дунд явуулсан санал асуулгын үр дүнгээр **ОХУ-ын төв банк бодлогын хүүгээ 2020 онд дахин бууруулна гэсэн хүлээлт өндөр байна**. Санал асуулгад оролцсон 21 шинжээчдийн үзэж

байгаагаар 2020 онд Оросын эдийн засаг 3.8 хувиар агшиж, 2021 онд 3 хувиар өсөхөөр байна. ОХУ-ын эдийн засаг 2020 оны II улиралд хамгийн ихээр буюу 9.1 хувиар, III улиралд 4.9 хувиар, IV улиралд 3.6 хувиар, 2021 оны I улиралд 2.1 хувиар тус тус агшина гэж үзжээ. Санал асуулгын үр дүнгээр ОХУ-ыг төв банк 6-р сард бодлогын хүүгээ 5 хувьд хүргэж бууруулах төлөвтэй байгаа аж.

- **Сингапур улс 2 сарын турш үргэлжилсэн чангатгасан хөл хориог сулруулж эхэллээ**. Эхний ээлжинд зарим сургуулиуд болон бизнесүүдийн үйл ажиллагааг нээх зөвшөөрөл олгож, нийт ажилчдын 1/3 нь ажилдаа эргэн орж эдийн засгийн идэвхжлийг 75 хувьд хүргэхээр төлөвлөж байна. **2020 онд Сингапурын эдийн засаг** 1965 онд тусгаар тогтносноос хойш анх удаагаа хамгийн ихээр буюу 7 хувиар агшиж болзошгүйг эдийн засагчид онцолж байна.
- **АНУ, БНХАУ хоорондын харилцаа таагүй хэвээр байна**. БНХАУ КОВИД-19-ийн улмаас бусад орны агаарын компаниудын БНХАУ-руу хийх нислэгийн зөвшөөрлийг хязгаарласан нь одоог хүртэл хүчинтэй хэвээр байгаа бөгөөд Трампын Засгийн газар БНХАУ-ын зүгээс АНУ-ын агаарын компаниудад нислэгийн зөвшөөрлийг сэргээхгүй тохиолдолд БНХАУ-ын агаарын компаниудын АНУ-руу хийх нислэгүүдийг хориглоно гэж сүрдүүллээ.

2 ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **Хятадын эдийн засаг** энэ оны 4-р сарын 3-ны байдлаар 90-95 хувийн потенциал ажиллаж байсан бол 6-р сарын 2-ны байдлаар КОВИД-19-ийн өмнөх түвшний **80-85 хувийн потенциал ажиллаж байгааг** ² Блүүмбергийн үзүүлэлтүүд харуулж байна. Хэдийгээр энэ нь 1-р сард 55 хувийн потенциал түвшнээр ажиллаж байсан үетэй харьцуулахад эерэг дохио боловч, хөл хорионы арга хэмжээг сулруулаад 2 сар өнгөрч байхад сэргэлт төдийлөн эрчимжээгүй байгаа нь эрсдэлийн дохио болж болзошгүй аж.
- **Хятадын аж үйлдвэрийн Caixin PMI индекс 5-р сард 50.7 хүрч, аж үйлдвэрлэлийн идэвхжил алгуур сэргэж байгаа хэдий ч, хэвийн түвшинд хүрэх хараахан болоогүй байна.** Индексийн бүлгүүдээр задалж харвал хөдөлмөр эрхлэлтийн түвшин 5-р сард өмнөх сараас бага зэрэг сэргэсэн хэдий ч, агшилттай хэвээр байна ³. Индексийн бүрэлдэхүүн дундаас үйлдвэрлэлийн салбар 3 сар дараалан тэлснээр сэргэлт үргэлжлэх дохио өгч байгаа бол захиалгын бүлэг бууралттай хэвээр байгаа нь үйлчилгээний эрэлт төдийлөн нэмэгдээгүйг илтгэж байна.
- **Хятадын аж үйлдвэрийн PMI индекс 5-р сард хүлээлтээс доогуур буюу 50.6 байсан бол аж үйлдвэрлэлийн бус PMI индекс хүлээлтээс өндөр буюу 53.6-д хүрчээ.** Энэ нь аж үйлдвэрлэлийн идэвхжил болон дотоод эрэлт алгуур сэргэж байгаа хэдий ч, хэвийн түвшинд хүрэх болоогүй хэвээр байгааг илтгэж байна (Зураг 3). Аж үйлдвэрлэлийн PMI индексийн бүлгүүдээр задалж харвал бизнес эрхлэгчдийн сентимент 63.9-д хүрч нэмэгдэв. Харин аж үйлдвэрлэлийн бус PMI индексийн бүлгүүдээр задалж харвал тээвэр, харилцаа холбоо, хоолны хүргэлт зэрэг үйлчилгээний салбарын идэвхжил нэмэгдсэн, соёл, үзвэр үйлчилгээний салбарын бизнесийн идэвхжил 50-аас доогуур түвшинд хадгалагджээ. Барилгын салбарын идэвхжил 60.8-д хүрч 4-р сарын 59.7-г давсан нь томоохон төслүүдийг дэмжих хүрээнд төсвийн зарцуулалт нэмэгдсэнтэй холбоотой байна.
- **БНХАУ-ын гангийн нийт экспорт** оны эхний 4 сард 20.6 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс 11.8 хувиар буурсан бол гангийн импорт 4.2 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 9.3 хувиар нэмэгдсэн байна.
- **Коксжих нүүрсний нийт импорт 4-р сард** өмнөх оны мөн үеэс 15.4 хувиар буурч 6.3 сая тоннд хүрсэн бөгөөд оны эхний 4 сараар авч үзвэл 27.3 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар нэмэгджээ. Хятадын коксжих нүүрсний экспорт ⁴ 4-р сард 0.14 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 30.5 хувиар буурсан, оны эхний 4 сараар авч үзвэл 0.35 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс 49.4 хувиар буурсан байна.
- **БНХАУ-ын Засгийн газар дотоодын нүүрсний үйлдвэрлэлээ дэмжиж, эрчим хүчний нүүрсний импортоо бууруулах төлөвтэй байна.** Хятадын

² Блүүмбергийн шинжээчдийн тооцоо. Энэ тооцоонд вирусийн голомт Хубэй муж ороогүй болно.

³ Тус индекс нь илүү олон жижиг аж ахуй нэгжүүдийн хамруулдаг бөгөөд Төрийн зөвлөлийн мэдээллээр жижиг, дунд аж ахуй

нэгжүүд хот суурин газрын нийт хөдөлмөр эрхлэлтийн 80 хувийг бүрдүүлдэг байна

⁴ Хятадын нүүрсний экспортын голлох хэрэглэгчид нь Өмнөд Солонгос, Индонез, Малайз зэрэг улс орнууд юм.

эрчим хүчний нүүрсний импорт оны эхний 4 сард 99.6 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 30.9 хувиар нэмэгдсэн бол оны эхний 4 сард эрчим хүчний нүүрсний нийт экспорт 1.05 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 35.8 хувиар буурав. Австралийн эрчим хүчний нүүрсний импорт оны эхний 4 сард 23.5 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 71.5 хувийн өсөлттэй байсан бол хил дээрх импортын нүүрсний хориг чангарснаар 5 болон 6-р сард импортын нүүрсний хэмжээ буурах төлөвтэй байна. Энэ онд Хятадын Засгийн газраас нүүрсний импортын зорилт тавиагүй боловч өмнөх жилийн 280 сая тонн орчимд хадгалах төлөвтэй гэж салбарын удирдлагууд үзэж байна.

- **Хятадын төсвийн бодлого:** Хятадын Ардын Их Хурлаар **2020 оны төсвийн алдагдлыг өсгөж, ДНБ-ий 3.6 хувьд** хүргэхээр баталлаа. Төсвийн бодлогын хүрээнд тусгай зориулалттай Засгийн газрын бондын арилжаа болон орон нутагт олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг авснаар 2020 онд Хятадын Засгийн газар 4-5 их наяд юанийн төсвийн зарцуулалт хийх төлөвтэй байна.

- **Хятадын мөнгөний бодлого:** Хятадын Ардын Их хурлаар эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан мөнгөний уян хатан бодлого баримтална гэдгийг мэдэгдэв. Хятадын Ардын Банк (ХАБ) энэ онд КОВИД-19-өөс үүдэн дотоод эдийн засагт ирэх дарамтыг саармагжуулахын тулд бодлогын хүүгээ 0.5-0.6 нэгж хувиар бууруулах хүлээлттэй байна⁵. Түүнчлэн, ХАБ 6-р сарын 1-ний мэдэгдэлдээ 400 тэрбум юанийн квоттой арилжааны банкуудын жижиг аж ахуй нэгжүүдэд олгосон зээлийг худалдаж авах зээлийн шинэ бодлогын хэрэгсэл хэрэглэнэ гэдгээ мэдэгдлээ. Энэхүү шинэ хэрэгслээр дамжуулж ХАБ арилжааны банкуудаас олгосон зээлийн 40 хувийг авах боловч, зээлийн эрсдэлийг хүлээхгүй бөгөөд хүүгийн орлогыг авахгүй юм. Мөн цаашид дунд хугацааны зээлийн хүүг бууруулах, жижиг дунд бизнесүүдэд хөнгөлөлттэй зээлийн нөхцөлийг дэмжих зэрэг арга хэмжээг авах хүлээлттэй байна.

⁵ ХАБ өмнө нь бодлогын хүүгээ 0.3-0.4 нэгж хувиар бууруулах хүлээлттэй байсан.


3 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ

ААН-ийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа:

Монголбанкнаас явуулсан түүвэр судалгааны үр дүнгээр КОВИД-19 цар тахал, халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь ААН-үүдийн 45%-д маш ихээр, 28%-д дунд зэрэг, 15%-д бага зэрэг нөлөөлсөн байна.

Энэхүү нөлөөг салбараар ангилан харвал аялал жуулчлал, боловсрол, зочид буудал, нийтийн хоол болон тээвэр агуулахын үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлж буй ААН-үүдэд хамгийн их сөрөг нөлөө үзүүлсэн байна. Харин хөдөө аж ахуй, эрүүл мэнд, үл хөдлөх хөрөнгө, барилга болон мэдээлэл харилцаа холбооны салбарын ААН-үүдийн үйл ажиллагаанд харьцангуй бага нөлөөлжээ.

Зураг 1. КОВИД-19 цар тахлын ААН-ийн үйл ажиллагаанд нөлөөлсөн байдал, салбараар




Эх сурвалж: Монголбанк

Судалгаанд хамрагдсан нийт ААН-үүдийн 58% нь бизнесийн зээлтэй байгаа бөгөөд КОВИД-19 цар тахлаас хамааран эдгээр ААН-үүдийн дийлэнх буюу 87%-д нь зээлийн эргэн төлөлттэй холбоотойгоор хүндрэл тулгарсан байна.

Монголбанкны зүгээс хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүд нь тус ААН-үүдэд дэмжлэг үзүүлсэн эсэхийг тодруулахад гурван ААН тутмын нэг буюу 29% нь зээлийн эргэн төлөлттэй холбоотой хүндрэлийг бууруулахад дэмжлэг үзүүлсэн, 51% нь дэмжлэг үзүүлээгүй гэж хариулжээ.

Зураг 2. Зээлийн хүндрэл, Монголбанкны дэмжлэг



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл:

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө 84.3%-тай биелж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.5%-аар буурсан байна. 2020 оны 4 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн нийт орлого 2,676.8 тэрбум төгрөг гарсан нь төлөвлөснөөс 15.7%-аар буюу 497 тэрбум төгрөгөөр дутсан үзүүлэлт байна.

Татварын орлогын дэлгэрэнгүй задаргааг авч үзэхэд 2020 оны 4 дүгээр сард нийт 540.6 тэрбум төгрөгийн татварын орлого бүрдэний 14% (73.4 тэрбум төгрөг) нь ААНОАТ, 12% (67.5 тэрбум төгрөг) нь ХХОАТ, 20% (106.5 тэрбум төгрөг) нь НДШ, 27% (147 тэрбум төгрөг) нь НӨАТ, 28% (152.5 тэрбум төгрөг) нь бусад татварын орлого байна.


Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэл 73.3%-тай гарсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.7%-аар өссөн үзүүлэлт бөгөөд урсгал зардал болон хөрөнгийн зардал харгалзан 18.7% (464.2 тэрбум төгрөг), 21.9% (68.7 тэрбум төгрөг)-иар өсжээ.

Хүснэгт 1. Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж

	Төсөв	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Татварын орлого	2,841,871	2,453,190	86.3%	-388,680
Татварын бус орлого	331,919.0	223,572	67.4%	-108,347
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж	3,173,790	2,676,763	84.3%	-497,027

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

Зураг 3. Татварын орлогын задаргаа, сараар



Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

Хүснэгт 2. Нийт зарлага ба цэвэр зээл

	Төсөв	Гүйцэтгэл	Хувь-1	Зөрүү
Урсгал зардал	3,509,301	2,942,143	83.8%	-567,158
Хөрөнгийн зардал	1,005,516	381,891	38.0%	-623,625
Цэвэр зээл	14,521	-3,784	-26.1%	-18,305
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	4,529,339	3,320,250	73.3%	-1,209,088

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн зарим зохицуулалттай холбогдуулан хэрхэн хэрэгжүүлэх тухай танилцуулгыг Монголбанк гаргалаа.

Монголбанк валютын зохицуулалтын хүрээнд богино хугацааны ханшийн хэлбэлзлээс ашиг олох арилжааны үйл ажиллагааг хязгаарлах, төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг нэг мөр хэрэгжүүлэх агуулгаар Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т “Тадаад валютын мөнгөн хадгаламж” гэж, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “үнэ тогтоох” гэсний дараа “мөнгөн төлбөрийн үүрэг гүйцэтгэх” гэж тус тус нэмэх хуулийн төслийн саналыг УИХ-д уламжилсан болно.

Мөн банкны бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн хүү нь зээлийн хүүний 65 орчим хувийг бүрдүүлдэг тул банкны эх үүсвэрийн зардлыг, улмаар зээлийн хүүг бууруулах зорилгоор Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Харилцах дансанд хүү тооцохыг хориглоно.” гэж нэмэх саналыг УИХ-д мөн уламжилсан. УИХ-ын зүгээс эдгээр саналыг Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг

бууруулах тухай хуулийн 10.4 дэх хэсэгт тусгасан.

Иймд дээрх хуулийн 10.4 дэх хэсгийн зохицуулалтыг түүний үндэслэл, зорилгыг харгалзан, Иргэний хуулийн 217 дугаар зүйлд заасан “мөнгөн төлбөрийн үүрэг гүйцэтгэх”, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуультай уялдуулан хэрэгжүүлнэ.

Банкны харилцах дансанд хүү тооцохгүй талаар: Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 19.1. дэх хэсэгт “Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэж заасан тул 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөр тасалбар болгон харилцах дансны үлдэгдэлд хүү тооцохгүй. Өөрөөр хэлбэл, банкнаас харилцагчид үзүүлж байгаа төлбөрийн үйлчилгээний гэрээ, хэлцэл нь уг хуульд нийцсэн байх шаардлагыг хангаж, хүчин төгөлдөр бус болох эрсдэлээс сэргийлэх шаардлагатай юм.

Иймд цар тахлын улмаас санхүүгийн зуучлал тасалдах, хүртээмж буурах эрсдэлээс сэргийлэх, зээлийн эх үүсвэрийн зардлыг нэмэгдүүлэхгүй байх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах замаар нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор батлагдсан тус хуулийн 3.1 дэх хэсэгт “Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулах”-аар заасны дагуу 10.4 дэх хэсгийг хууль

хүчин төгөлдөр болохоос өмнөх харилцаанд мөн адил хамруулан, харилцагчтай байгуулсан гэрээний нөхцөлд холбогдох өөрчлөлтийг оруулах ёстой гэж үзсэн билээ.

Энэхүү арга хэмжээг харилцах дансыг хугацаагүй хадгаламжид хөрвүүлэхээс зайлсхийж, банкууд харилцан ойлголцож, нэгдсэн стандарт мөрдүүлэн хэрэгжүүлнэ.

Гадаад валютын хадгаламжийг албан журмын даатгалд хамруулахгүй талаар: Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10.4 дэх хэсэгт заасны дагуу хууль хэрэгжих хугацаанд гадаад валютын хадгаламж нь хадгаламжийн даатгалд хамаарахгүй буюу даатгалын тохиолдол бий болоход нөхөн төлбөр төлөхгүй. Харин Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйл хүчин төгөлдөр үйлчилж байгаа тул гадаад валютын хадгаламж нь хадгаламжийн даатгалын хураамжаас чөлөөлөгдөхгүй.

Иргэн, хуулийн этгээд хоорондын гүйлгээг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх талаар: Иргэний хуулийн 217.1. дэх хэсэгт “Мөнгөн төлбөрийн үүргийг Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөгөөр гүйцэтгэнэ.”, 217.2 дэх хэсэгт “Хуулиар хориглоогүй бол талууд мөнгөн төлбөрийн үүргийг гадаадын мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэж болно.”, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1 дэх хэсэгт “Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас


бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно.”, 4.4 дэх хэсэгт “Банк, банк бус санхүүгийн байгууллагын мөнгөн хадгаламж, зээл, тэдгээртэй адилтгах аливаа үйлчилгээ, санхүүгийн үүсмэл хэрэгсэлтэй холбоотой байгуулах гэрээ, түүгээр хүлээх үүргийг гадаад валютаар илэрхийлж, гүйцэтгэлийг гадаад валютаар хангуулж болно.” гэж тус тус заажээ.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10.4 дэх хэсэгт заасан “Иргэн, хуулийн этгээд хоорондын гүйлгээг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх” гэсэн заалт нь Иргэний хууль болон Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуультай нягт уялдсан бөгөөд дээр дурдсан тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанаас бусад иргэн, хуулийн этгээдийн мөнгөн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг “төгрөгөөр” гүйцэтгэх агуулгаар хэрэгжүүлнэ. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдэх иргэн хуулийн этгээд хоорондын (иргэн хооронд болон хуулийн этгээд хооронд мөн адил хамаарна) бараа, ажил, үйлчилгээний үүргийн гүйцэтгэлийг “төгрөгөөр” гүйцэтгэнэ. Харин банк хуулийн хэрэгжилтийг хангахдаа харилцагчаас гүйлгээний зориулалт нь ямар зориулалттай болохыг нягтлан, харилцагчид Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа, ажил үйлчилгээний төлбөрийг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг мэдэгдэн, холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай.

5 ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭД ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ

Газрын тосны үйлдвэрлэлийн гарцаа танах ОПЕК-ийн Өргөтгөсөн бүлгийн хэлцэл болон зарим улсад хориг арга хэмжээг аажмаар сулруулж, газрын тосны эрэлт буцаж нэмэгдсэнээр сүүлийн 3 долоо хоногт газрын тосны үнэ сэргэж 36 ам.долларт хүрээд байна. Хятад улсад шинэ коронавирусийн тархалт намжиж, эдийн засаг нь идэвхжиж, үйлдвэрүүдийн үйл ажиллагаа сэргэсэнтэй холбоотойгоор зэсийн ханш сүүлийн 2 сарын хугацаанд 17 хувиар өсөж 5400 ам.долларт хүрлээ. Харин төмрийн хүдрийн нийлүүлэлтэд тасалдсанаар төмрийн хүдрийн үнэ огцом өсөж 91 ам.долларт хүрчээ. Дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал, эрсдэл өндөр байгаа тул алтны ханш 1700-1750 ам.долларын түвшинд хэвээр хадгалагдаж байна.


Зураг 4. Зэсийн үнэ



Зэсийн үнэ. Манай улсын гол экспортын бүтээгдэхүүнүүдийн нэг болох зэсийн үнэ ч мөн адил КОВИД-19 цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор огцом унасан бөгөөд 3 дугаар сарын 23-ны байдлаар 4609 ам.долларт хүрч буурсан нь сүүлийн 4 жилийн хамгийн доод түвшин юм. Харин дэлхийн зэсийн эрэлтийн тал хувийг дангаар бүрдүүлдэг БНХАУ-ын үйлдвэрүүд үйл ажиллагаагаа сэргээж, тус улсын зэсийн импорт огцом өссөнтэй холбоотойгоор сүүлийн хоёр сарын хугацаанд зэсийн үнэ аажмаар буцаж сэргэн

5,500 ам.долларын түвшинг давлаа. Нөгөө талд, зэсийн гол нийлүүлэгч Перу, Чили зэрэг улсад коронавирусийн халдвар эрчимтэй тархаж буй нь зэсийн үнэ эргэж өсөхөд нөлөө үзүүлж байна.

Зураг 5. Газрын тосны үнэ




Газрын тосны үнэ. 2020 оны эхэнд АНУ, Ираны зөрчлийн улмаас брент төрлийн газрын тосны ханш 70 орчим ам.долларт хүрсэн. КОВИД-19 цар тахал дэлхийн олон оронд эрчимтэй тархаж, улс орнууд хилийн хориг, хариу арга хэмжээ авснаар дэлхийн аялал жуулчлал, тээврийн салбарын үйл ажиллагаа хумигдаж, үүнийг дагаад түлш, шатахууны эрэлт буурч байна. Нөгөө талдаа, томоохон газрын тос нийлүүлэгч ОХУ, Саудын Араб зэрэг улсууд үйлдвэрлэлээ

нэмэгдүүлэх шийдвэр гаргасны улмаас дэлхийн зах зээл дээр газрын тосны илүүдэл үүсэж, 3 дугаар сард газрын тосны үнэ тасралтгүй буурсан. 5 дугаар сарын 1-ээс эхлэн ОПЕК-ийн Өргөтгөсөн бүлгийн газрын тосны гарц танах хэлэлцээр хэрэгжсэн. Мөн


зарим улсууд хориг арга хэмжээгээ аажмаар сулруулж газрын тосны эрэлт буцаж сэргэж эхэлсэнтэй зэрэгцэн газрын тосны үнэ өсөж 40 ам.долларт хүрлээ.

Зураг 6. Алтны ханш



алтны ханш 1500 орчим ам.долларт хүрч огцом буурсан. Гэвч 4 дүгээр сараас эхлэн дэлхийн улс орнуудад ээлжлэн вирусийн тархалт эрчимтэй нэмэгдсэн, АНУ болон Хятад улсуудын харилцаа таагүй байгаа зэрэг нь дэлхийн эдийн засагт тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, алтны ханш буцаж сэргэн 1700-1750 ам.долларт хэлбэлзэж байна. Энэ нь 2019 оны мөн үетэй харьцуулахад 32 хувиар буюу 420 гаруй ам.доллараар өндөр юм.

Зураг 7. Төмрийн хүдрийн үнэ



төмрийн хүдрийн үнэ харьцангуй тогтвортой 80-84 ам.долларын хооронд хэлбэлзэж байсан бол гол нийлүүлэгчид болох Бразил, Энэтхэг улсад шинэ коронавирусийн халдвар хурдтай тархаж, төмрийн хүдрийн нийлүүлэлтийн хувьд тодорхойгүй байдал үүсэхтэй зэрэгцэн сүүлийн нэг сарын хугацаанд төмрийн хүдрийн ханш 22.5 хувиар чангарч 100.7 ам.долларт хүрлээ. Энэхүү төмрийн хүдрийн нийлүүлэлтийн хомстол 7 сар хүртэл үргэлжилж болзошгүй хэмээн шинжээчид үзэж байна.

Алтны ханш. Дэлхийн эдийн засагт аливаа хямрал, тодорхой бус байдал үүсэхтэй зэрэгцэн алтны ханш огцом өсдөг. Үүнтэй холбоотойгоор 2020 оны эхний улиралд 6.9 хувиар өссөн нь 6 улирал дараалан алтны үнэ өссөн үзүүлэлт юм. 3 дугаар сарын эхэн үеэс Хятад улсад тархалт буурч, ихэнх улсуудын засгийн газар, төв банкууд КОВИД-19-ийн сөрөг үр нөлөөг бууруулах, эдийн засгаа дэмжих арга хэмжээг шийдэмгий авч байсантай холбоотойгоор

Төмрийн хүдрийн үнэ. 2019 оны 11 сараас төмрийн хүдрийн ханш тасралтгүй өссөөр 2020 оны эхний сард 95 ам.долларт хүрсэн. Дэлхийн нийтэд төмрийн хүдрийн импортын 70%-ийг бүрдүүлдэг Хятад улсад КОВИД-19-ийн улмаас цагаан сарын амралт урт хугацаанд үргэлжилж, аж үйлдвэрүүд зогсонги байдалд орсон нь төмрийн хүдрийн эрэлт буурахад нөлөөлсөн. Ингэснээр 2 дугаар сарын эхэнд төмрийн хүдрийн үнэ 15.3 хувиар огцом унаж 78.3 ам.долларт хүрчээ. 4 дүгээр сард